

БИЧИЛ УУРХАЙН НӨХӨРЛӨЛТЭЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭ

2017-06-02.

Дугаар-02

Дархан

Монгол улсын Газрын тухай хуулийн 16-р зүйлийн 16.1.11 дэх заалт, 21-р зүйлийн 21.4.3 дах заалт, Засгийн газрын 2017 оны 151-р тогтоолоор баталсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 2.4, 3.1.3, 6.1.3 дах заалт, Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 05-р сарын 10-ны 35 тоот тогтоолын дагуу нэг талаас Булган аймгийн Бүрэгхангай сумын Засаг дарга **Нацаг овогтой Эрхэмбаяр** (цаашид "Засаг дарга" гэх), нөгөө талаас бичил уурхайн "**Наран-Эрдэнэ**" нэртэй бүртгэгдээгүй нөхөрлөл (цаашид "Нөхөрлөл" гэх)-ийг төлөөлж нөхөрлөлийн ахлагч **Сандагсүрэн** овогтой **Нарантуяа** нар харилцан тохиролцож энэхүү гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Нөхөрлөл нь Булган аймгийн Бүрэгхангай сумын Дэрст багийн "Туулын цагаан тохой" нэртэй газарт орших 1,43 гектар /га/ талбайн өөрт харгалзах 1,69 гектар /га/ талбайд гэрээнд заасан хугацаагаар алт олборлох үйл ажиллагаа эрхлэнэ. Солбилцол:

№	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	104	31	53,00	48	29	00,82
2	104	31	54,48	48	29	01,12
3	104	32	01,01	48	29	01,13
4	104	32	01,00	48	28	58,17
5	104	31	53,00	48	28	58,17

1.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сумын Засаг дарга, нөхөрлөлийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

Хоёр. Сумын Засаг даргын эрх, үүрэг

2.1. Сумын Засаг дарга нь "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох зам"-ын 6-д зааснаас гадна дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

2.1.1. Нөхөрлөлд ногдох талбайн хэмжээг ~~тогтоож~~ талбайн байршлын ~~зургийг~~ гэрээнд хавсаргах;

Бүртгэл
19 04 08

2.1.2. Нөхөрлөлийн гишүүдийн амьдрах суурьшлын бүс болон хог хаягдлын цэгийн байршлыг тогтоож өгөх;

2.1.3. Нөхөрлөлд ногдох талбайн хэмжээтэй уялдуулан олборлолт явуулсан талбайд хийх техникийн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг тооцож, нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх мөнгөний хэмжээ, хугацааг нөхөрлөлтэй харилцан тохиролцож зохих хөрөнгийг төвлөрүүлэх;

2.1.4. "Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм"-ийг дагаж мөрдөж байгаа эсэх, ажлын байрны зааварчлага өгөх үүргээ нөхөрлөлийн ахлагч биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

2.1.5. Гишүүдийг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга барилд сургах ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар зохион байгуулах;

2.1.6. Нөхөрлөлийн олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдах үйл ажиллагаанд хяналт тавих, олборлолтын мэдээ хөтлүүлэх;

2.1.7. Нөхөрлөлийн гишүүдэд эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдахын ач холбогдолыг тайлбарлан таниулах ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар зохион байгуулах, эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамруулах.

2.1.8. Нөхөрлөлөөс талбайг буцааж хүлээлгэж өгөхийн өмнө хийсэн нөхөн сэргээлтийн ажлыг газар дээр нь байгаль орчны хяналтын байцаагчийн дүгнэлт гаргуулан, комисс томилж хүлээж авах;

2.1.9. Нөхөрлөлд ашигт малтмал олборлох талбай дахин олгох асуудлыг шийдвэрлэх;

2.1.10. Нөхөрлөлд гэрээгээр олгосон талбай дээр нөхөрлөлийн гишүүн бус этгээд ажиллаж буй эсэхэд хяналт тавих;

2.1.11. Нөхөрлөлийн гишүүдэд бичил уурхай эрхлэгчийн хувьд хууль тогтоомжийн дагуу татвар төлөх үүргийг нь тайлбарлан таниулж, татварын үүрэг биелүүлэхтэй нь холбогдсон сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

2.2. Засаг дарга дараах эрхтэй. Үүнд:

2.2.1. "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 3-т заасан эрх эдэлнэ;

2.2.2. Нөхөрлөлд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

2.2.3. Нөхөрлөлийн ахлагчид үүрэг даалгавар өгөх, гүйцэтгэлийг шалгах;

2.2.4. Гэрээний үүргээ биелүүлээгүй, ашигласан талбайн нөхөн сэргээлт хийгээгүй нөхөрлөлийн ашигт малтмал олборлох үйл ажиллагааг үүр зогсоож, хугацаатай үүрэг өгч биелэлтийг тооцох, гэрээг цуцлах;

2.2.5. Хүн, мал, байгаль орчинд харш үйл ажиллагааг зогсоох;

Гурав. Нөхөрлөлийн эрх, үүрэг

3.1. Нөхөрлөл дараах үүрэгтэй. Үүнд:

3.1.1. Нөхөрлөлийн гишүүдийг тогтоосон бүсэд суурьшуулах;

3.1.2. Нөхөрлөл нь гэрээнд заасан талбайн хил, хязгаарын дотор үйл тагаа явуулах;

3.1.3. Байгаль орчныг хамгаалах, гол ус, булаг шанд, уст цэгүүдийг хуульчилж идуулахгүйгээр зүй зохистой хэрэглэх;

3.1.4. Орчны тохижилт хийх, хог, хаягдлын цэгийг байгуулах, хог хаягдлын байгуулах;

3.1.5. Бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөх, осол аваараас урьдчилан сэргийлэх арга техникт суралцах;

3.1.6. Байгаль орчныг нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх талаар болгож сумын Засаг даргын тогтоосон байгаль орчны нөхөн сэргээлтийн шалтгаанд шаардагдах төгрөгийг га тутамд 5.000.000 /Таван сая/ тооцож Байгаль орчны хамгаалах санд төвлөрүүлэх;

3.1.7. Байгаль хамгаалах санд төвлөрүүлсэн мөнгийг нөхөрлөл нөхөн элт хийсний дараа БОХУБ-ын дүгнэлтийг үндэслэн буцааж олгоно.

3.1.8. Талбайг хүлээлгэн өгөхийн өмнө нөхөн сэргээлт хийж сумын байгаль орчны хяналтын улсын байцаагчаар дүгнэлт гаргуулан, сумын Засаг даргын тогтоосон комисст хүлээлгэн өгөх;

3.1.9. Олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдан эрх бүхий хуулийн этгээдэд худалдана;

3.1.10. Бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа болон байгаль орчны нөхөн сэргээлт хийхэд чиглэгдсэн сургалт, сурталчилгаанд үндийг идэвхитэй оролцуулах;

3.1.11. Холбогдох хууль тогтоомжийн дагуу бичил уурхай эрхлэгч иргэн АТ сар бүр 20000 /Хорин мянган/ төгрөг төлөх;

3.1.12. Хууль ёс, нийгмийн хэв журмыг зөрчсөн аливаа үйлдэлтэй хамт тусгай ороо тэмцдэг байх;

3.1.13. Үйл ажиллагаандаа химийн хорт болон **аюултай бодис ашиглахгүй** байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад **Тохиолдолд тэсэрч** байх, эрх бодис, тэсэлгээний хэрэгсэлийг ашиглахгүй байх;

Бичигтэйгээр
ТӨГӨӨР

19 04 08

Зургаа. Гэрээний үйлчлэх хугацаа

6.1. Энэхүү гэрээ нь 2017 оны 06 сарын 02-ны өдрөөс 2017 оны 11 сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд үйлчилнэ. Талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болно.

6.2. Бичил уурхайн нөхөрлөл гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн тохиолдолд цаашид нэг удаа гэрээг сунгаж ажиллана.

6.3. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэж өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.

6.4. Гэрээний хавсралтууд нь түүний салшгүй хэсэг байна.

6.5. Гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

Гэрээ байгуулсан:

БҮРЭГХАНГАЙ СУМЫН ЗАСАГ

ДАРГА:

/Н.ЭРХЭМБАЯР/

Хаяг: Булган аймгийн Бүрэгхангай сумын 4-р баг Дархан, ЗДТГ.

Утас: 94003133, 80093133.

e-mail: n.erkhembayar99@gmail.com

"НАРАН-ЭРДЭНЭ" НӨХӨРЛӨЛИЙН

АХЛАГЧ: *Улаансүрэг*

/С.НАРАНТУЯА/

Хаяг: Булган Бүрэгхангай 4-р баг Дархан.

Утас: 88010072.

e-mail:

Бүртгэлийн дугаар:

НЭМЭГ

19 04 08